



ТӨВ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХДИ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2019 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 03

Зуунмод

Г Зуунмод, Сэргэлэн сумын хилийн цэсэд өөрчлөлт оруулах санал цэсэд өөрчлөлт оруулах санал уламжлах тухай

Аймгийн Засаг дарга Ж.Батжаргалын Зуунмод сумын хилийн цэсэд өөрчлөлт оруулах санал уламжлах шийдвэрийн төсөл боловсруулсан тухай мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Төв аймгийн Зуунмод сумын /тэр үеийн Зуунмод хотын/ хилийн цэсийг тухайн үеийн Аймгийн Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх захиргааны 1971 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 02 дугаар тогтоолоор санал уламжилж, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1971 оны 12 сарын 8-ны өдрийн 252 дугаар зарлигаар батлан, 1918 га нутаг дэвсгэртэй байхаар тогтоон одоо болтол мөрдөж байна.

Зуунмод хотын нутаг дэвсгэрийг тогтооходоо, тус хотын мал бүхий иргэдийг зайдуу гаргаж “Малчдын хороолол” нэртэйгээр хотын хилийн цэсийн гадна талд, Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт байршуулсан байна.

Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиуд 1990-ээд оны эхээр батлагдаж, засаг захиргааны нэгжийн зохион байгуулалтыг хийхэд Зуунмод хотыг сум болгож, 6 багтай байхаар, “Малчны хороолол”-ыг Зүүндэлгэр баг болгон Зуунмод сумын Засаг захиргааны нэгжээр тогтоож, сумын нутаг дэвсгэрийн багтаамжаас шалтгаалан хуучнаар нь Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт суурьшуулсан байна.

Зуунмод сумын нэг баг Сэргэлэн сумын нутагт байршиж байгаатай холбогдон зарим зөрчил, санал гомдол гарч байсан тул энэ асуудлыг шийдвэрлүүлэхээр 1997 оноос хойш Зуунмод сумын хилийн цэсэд өөрчлөлт оруулах, шинэчлэн тогтоолгох саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 5 удаа хэлэлцэж, зохих тогтоол шийдвэр гарган холбогдох эрх бүхий дээд шатны байгууллагад уламжилсан боловч, енөөг хүртэл шийдвэрлэгдээгүй байна.

Улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн эргэлтийн цэгүүдийг солбицолжуулах ажлыг 2013 онд гүйцэтгэж, газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлан, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэн, 2017 оноос Газрын мэдээллийн сангийн Лэнд менежер программ хангамжийг нэвтрүүлэн, тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн хүрээнд Засаг даргын захирамжаар эрх зүйн харилцаа үүссэн газрыг бүртгэж баталгаажуулах болсон тул Зуунмод сумын хилийн цэсийн гадна байгаа Зүүндэлгэр багийн иргэн, хуулийн этгээдийн эзэмшил, өмчлөлийн газар мэдээллийн программд бүртгэгдэх боломжгүй болсон байна. Өөрөөр хэлбэл энэ багт оршин сууж буй иргэд, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын

0100003

хашаа, үл хөдлөх хөрөнгөд хаяг, хаалганы дугаар олгоход хуулийн дагуу нутаг дэвсгэрийн харьяллаараа Сэргэлэн сумын 4 дүгээр багийн хаягтай байх шаардлагатай болж, энд олон жил суурьшин амьдарсан Зуунmod сумын иргэд Сэргэлэн сумын харьят болох, шилжилт хөдөлгөөн хийх, бичиг баримт солих, Сэргэлэн сумас төрийн үйлчилгээ авахад хүрч хүндрэл бэрхшээл учирч, санал гомдол олноор гарч байна.

Одоогийн байдлаар Зуунmod сумын хилийн цэсийн гадна буюу Баруун Зуунmod 6-р баг Энхтайвны зүйн хойд талд 212, Зүүндэлгэр 4-р багт 1909, Ланс 2-р багийн хөтөлд 55, Баянхошуу 3-р баг хуучин нисэхэд 250, хогийн хөтөл орчимд 50 нийт 2477 иргэн, аж ахуй нэгжид газар эзэмшүүлж, өмчлүүлсэн бөгөөд эдгээр газрыг мэдээллийн санд оруулан, улсын бүртгэлд бүртгүүлэн гэрчилгээжүүлэх, өөрчлөлт хийх, шилжүүлэх, үл хөдлөх эд хөрөнгийн кадастрын мэдээллийг бүртгэхийн тулд Зуунmod сумын хилийн цэсэд өөрчлөлт оруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Зүүндэлгэр багийг иргэдийг Сэргэлэн сумын харьят болгон шилжүүлэхийг иргэд зөвшөөрөхгүй, асар их чирэгдэл, гомдол санал гарах тул тус багийг одоогийнхоор нь Зуунmod сумын баг хэвээр байлгаж хилийн цэсийг тэлж, шинэчлэн тогтоолгох нь зүйтэйг тэмдэглээд Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 20 дахь зүйлийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Төв аймгийн Зуунmod, Сэргэлэн сум хоорондын хилийн цэсэд өөрчлөлт оруулан шинэчлэн тогтоолгох саналыг дор дурдсан солбицолоор дэмжиж Монгол Улсын Их Хурал, Засгийн газарт уламжилсугай. Үүнд:

№	Хилийн цэсийн тоотын нэр	Өргөрөг /WGS84/	Үртраг /WGS84/
1	Өндөр довны хөтөл	47°42'44.8900"	106°55'21.5000"
2	1720.0 тоот	47°43'42.0900"	106°56'02.3000"
3	Номтын доод булаг	47°43'39.4900"	106°56'55.4900"
4		47°43'26.0797"	106°57'30.9473"
5		47°43'46.5931"	106°58'04.0584"
6		47°43'31.8168"	106°58'24.9649"
7	Зуунmodны гол ба Сүрьеэгийн больници руу чиглэсэн суваг хоёрын уулзвар /1-р шон/	47°43'12.5000"	106°58'06.8900"
8		47°42'50.8926"	106°58'14.2216"
9		47°42'34.3572"	107°00'24.8160"
10		47°42'12.2077"	107°00'51.4215"
11		47°41'28.3018"	106°59'41.8911"
12		47°41'37.7573"	106°58'55.6846"
13		47°41'26.8274"	106°58'57.3013"
14		47°41'19.9074"	106°59'01.4626"
15		47°41'14.8810"	106°59'03.6709"
16		47°41'05.5232"	106°59'15.4284"
17		47°40'32.1360"	106°59'04.8605"
18		47°40'00.4740"	106°58'02.1148"
19		47°39'54.6694"	106°57'09.1635"
20		47°39'43.2900"	106°57'04.9837"
21		47°39'43.3995"	106°56'50.4739"


22		47°40'06.1360"	106°56'44.0113"
23	Зуунмодны голын гарам /2-р шон/	47°40'40.1900"	106°56'31.0900"
24	Бараатын өврийн оршуулгын газрын баруун урд будан /3-р шон/	47°40'49.6000"	106°55'18.2000"
25	Их бараат уул /1699.7 тоот/	47°41'38.0900"	106°55'08.7000"
26	Их бараат уулын хойт толгой	47°42'11.4900"	106°55'02.6000"
27	Өндөр довын хөтлийн урд толгой	47°42'26.2900"	106°54'56.9900"

2. Зуунмод, Сэргэлэн сумдын нутаг дэвсгэрт оруулах өөрчлөлтийн тооцоог нэгдүгээр, Зуунмод, Сэргэлэн сумдын хилийн цэсэд өөрчлөлт оруулах нутаг дэвсгэрийн газрын зургийг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус дэмжсүгэй.

3. Зуунмод, Сэргэлэн сумын хилийн цэсэд өөрчлөлт оруулахад шаардлагатай холбогдох материалыг “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 2 дахь зүйлийн 19-д заасны дагуу бүрэн бүрдүүлж газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлэхийг аймгийн Засаг дарга /Ж.Батжаргал/-д даалгасугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.





Аймгийн иргэдийн Төлөөлөгчлийн Хурлын
2019 оны 05-дугаар сарын 13-ны өдрийн
13 дугаар хуувалдааны 03 дугаар тогтоонын
1 дүгээр хавсралт

**СЭРГЭЛЭН СУМ, ЗУУНМОД СҮМДҮН НУТАГ ДЭВСГЭРИЙН
ТАЛБАЙД ОРОХ ӨӨРЧЛӨЛТ**

№	Сүмийн нэр	Одоо байгаа талбай/га	Өөрчлөгдсөн нийт талбай	Нэмэгдэх хасандах талбай	ХАА газар	Хот тосгон бусад суурин газар	ЗШС газар	Ойн сан бүхий газар	Усан сан бүхий газар	Улсын тусгай хэрэцээний газар
1	Сэргээтэн	386574	385392	-1182	-610	-571.3	-0.7	0	0	0
2	Зуунмод	1918	3100	1182	610	571.3	0.7			

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2019 оны 06 сарын 13-ны өдрийн
13 дугаар хуралдааны 06 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт.

